



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2012 оны 08 сарын 08 өдөр

Дугаар 262


Улаанбаатар хот

“НИММ аудит” ХХК-ийн  
даатгалын байгууллагад аудит хийх  
эрхийг хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 149 дүгээр тогтоолоор батлагдсан “Даатгалын байгууллагад аудит хийх үйл ажиллагааг зохицуулах журам”-ын 2.10.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “НИММ аудит” ХХК-ийн даатгалын байгууллагад аудит хийх эрхийг хүчингүй болгосугай.
2. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН